



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/15

Мансхатговь

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 4.5.9, 4.5.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил сумдад мал амьтны гоц халдаврт шүлхий өвчин гарсан тул дээрх сумдыг 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

Хоёр. Сумдын Засаг дарга нарт энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосугай.

Гурав. Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан, Өндөршил сумын шуудан тээврийн хөдөлгөөн, Өлзийт, Хулд, Гурвансайхан, Дэлгэрхангай, Баянжаргалан сумдаас тээвэрлэж буй уул уурхайн баяжмал бүхий тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүн малын хөдөлгөөнийг 21 хоногийн хугацаагаар хориглосугай.

Дөрөв. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар /Я.Алтанхундага/, Цагдаагийн газар /Н.Ганбаатар/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-т тус тус даалгасугай.

Тав. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/06 дугаартай тоот захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0270040